## 6.0. Ойлголт

Энэхүү модулийн зорилго нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө бүртгэх, удирдах юм. ДБУМС-д сургалтын хөтөлбөр шинээр үүсгэх, засах, нэмэлт өөрчлөлт оруулах, баталгаажуулах, устгах, архивлах зэрэг үйлдлийг их, дээд сургууль, коллеж хийж гүйцэтгэх ба мэргэжлийн чиглэлийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг ДБУМС-ээр автоматаар шалгаж баталгаажуулна. БШУЯ, түүний харьяа байгууллага өөрийн эрх үүргийн хүрээнд хөтөлбөрийн холбогдох мэдээллийг харах, хянах ба улсын хэмжээний их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, real, статистик, аналитик тайлан харах, татах боломжтой.




Үйл ажиллагаа

Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө үүсгэхээс эхлэн баталгаажуулах, засах, баталгаажуулалт буцаах, устгах, архивлах зэрэг үйл ажиллагааг системд бүртгэх оролцогч, тэдгээрийн хийх үйлдэл, бүртгэх үеийн шалгуур зэргийг процессийн болон мэдээллийн урсгалын загвараар илэрхийлэн харуулсан болно. Энд дараах процессууд хамаарна. Үүнд:

- Хөтөлбөр, төлөвлөгөө үүсгэх, баталгаажуулах
- Хөтөлбөр, төлөвлөгөө засах
- Хөтөлбөр, төлөвлөгөөний баталгаажуулалт буцаах
- Хөтөлбөр, төлөвлөгөө устгах
- Хөтөлбөр, төлөвлөгөө архивлах

Шалгуур

### Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө **үүсгэх, баталгаажуулах шалгуур**

ДБСБ нь олгосон тусгай зөвшөөрлийн хүрээний мэргэжлийн чиглэл, индексээр сургалтын хөтөлбөр бүртгэнэ. Сургалтын хөтөлбөрийн бүртгэлд хөтөлбөрийн үндсэн мэдээлэл, хэрэгжүүлэх сургууль, сургалтын төлөвлөгөө болон төлөвлөгөөний бүтэц зэргийг бүртгэж, баталгаажуулна. Идэвхтэй төлөвтэй сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд суралцагч бүртгэх боломжтой болно.

Сургалтын хөтөлбөр баталгаажуулах хүсэлт илгээх үед системд баталгаажуулах шалгуур шалгаж, шалгуур хангасан нөхцөлд хөтөлбөр, төлөвлөгөөг идэвхтэй төлөвт оруулна.

Дараах **шалгуурууд** байна. Үүнд:

- Тусгай зөвшөөрлийн хугацаа хүчинтэй байх
- Тухайн сургалтын хөтөлбөрөөр сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа хүчинтэй байх
- Тусгай зөвшөөрөл дээрх мэргэжлийн чиглэлийн индекс, нэр, сургалтын хэлбэр, элсэгчдийн боловсролын түвшин, төгсөгчдөд олгох боловсролын зэрэг, агуулгын багтаамж, сургалтын хугацаа нь сургалтын хөтөлбөрийн харгалзах мэдээлэлтэй тохирч байх
- Сургалтын хөтөлбөрийн төлөв засварын горим эсвэл цуцлагдсан байх
- Хамгийн багадаа нэг төлөвлөгөө үүссэн байх
- Хамгийн багадаа нэг төлөвлөгөө идэвхтэй төлөвт байх эсвэл төлөвлөгөө баталгаажуулах шалгуур хангасан засварын горимд байх
- Хөтөлбөрийн төлөвлөгөөний бүтцэд бүртгэсэн агуулга нь тусгай зөвшөөрөл дээрх агуулгын багтаамжаас их буюу тэнцүү байх
- Түвшин тогтоох дүрэм нь “Цуглуулсан багц цаг” сонгосон тохиолдолд сургалтын түвшин тодорхойлох дүрэмд заасан багц цагийн нийлбэр тусгай зөвшөөрлийн харгалзах агуулгын багтаамжаас их буюу тэнцүү байх.

Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө засах **шалгуур**

Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний мэдээлэл буруу бүртгэсэн тохиолдолд засах үйлдэл хийнэ. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний мэдээлэл засах үйлдэл хийхэд төлвөөс хамаарч мэдээлэл засах боломж ялгаатай байна. Хөтөлбөр, төлөвлөгөөний төлөв засварын горимд байх үед засах боломжтой.

Сургалтын хөтөлбөр устгах **шалгуур**

Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө буруу бүртгэсэн тохиолдолд устгах үйлдэл хийнэ. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө устгах үйлдэл хийх үед шалгуур ажиллана. Хөтөлбөр, төлөвлөгөөнд суралцагч бүртгэгдсэн тохиолдолд устгах боломжгүй байна.

Дараах тохиолдолд устгах боломжтой байна. Үүнд:

- Хөтөлбөрийн төлөв засварын горим, идэвхтэй байх
- Суралцагч бүртгэлгүй байх

Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө архивлах **шалгуур**

ДБСБ нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө ашиглахаа болих үед архивлах үйлдэл хийнэ. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө архивлахын тулд тухайн хөтөлбөр, төлөвлөгөөнд бүртгэлтэй суралцагчдыг хөтөлбөр хооронд шилжүүлнэ. Архивласан төлөвтэй сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд суралцагч шинээр бүртгэх, шилжилт хөдөлгөөн хийх боломжгүй байна.

---

### 6.1. Сургалтын хөтөлбөр бүртгэх

**Хөтөлбөр нэмэх** үйлдэл нь системд нэвтэрсэн сургалтын байгууллагын хэрэглэгч олгосон тусгай зөвшөөрлийн мэргэжлийн чиглэл, индексийн хүрээнд сургалтын хөтөлбөр үүсгэж бүртгэнэ. Сургалтын хөтөлбөрийн бүртгэлд хөтөлбөрийн үндсэн мэдээлэл, хэрэгжүүлэх сургууль, сургалтын төлөвлөгөө зэрэг багтсан. Сургалтын хөтөлбөрийг шинээр үүсгэж хадгалахад хөтөлбөрийн нэр, индекс давхцахгүй байна.

Хөтөлбөр нэмэх үйлдэл хийхээс өмнө **ДАРААХ НӨХЦӨЛ** биелсэн байх шаардлагатай. Үүнд**:**

- Тусгай зөвшөөрлийг бүртгэсэн байх
- Тусгай зөвшөөрлийн төлөв баталгаажсан байх
- Тусгай зөвшөөрлийн хугацаа хүчинтэй байх

Сургалтын хөтөлбөр шинээр нэмж, бүртгэх үйлдлийг дараах дараалаар хийнэ. Үүнд:

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.
2. Сургалтын хөтөлбөрийн дэд хэсгээс **жагсаалт**ийг сонгоно.
3. Цонхны баруун дээд хэсэгт байрлах **Хөтөлбөр нэмэх** товчийг дарна.
4. Хөтөлбөр нэмэх цонхны мэдээллийг оруулаад **хадгалах** товч дарна.

Сургалтын хөтөлбөр нэмэх үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.




2. Сургалтын хөтөлбөрийн дэд хэсгээс **жагсаалт**ийг сонгоно.



3. Цонхны баруун дээд хэсэгт байрлах **Хөтөлбөр нэмэх** товчийг дарна.

4. Хөтөлбөр нэмэх цонхны мэдээллийг оруулаад **хадгалах** товч дарна.




---

### 6.2. Сургалтын хөтөлбөр баталгаажуулах

Сургалтын хөтөлбөрийн мэдээлэл бүртгэж, сургалтын хөтөлбөрийн доор хамгийн багадаа нэг төлөвлөгөө үүсгэж, төлөвлөгөөний бүтэц үүсгэсний дараа баталгаажуулах үйлдэл хийнэ.

Сургалтын хөтөлбөр баталгаажуулах үед системд баталгаажуулах шалгуур автоматаар шалгаж, шалгуур хангасан нөхцөлд хөтөлбөрийг идэвхтэй төлөвт оруулна. Бусад тохиолдолд засварын горимтойгоор хадгална. Хөтөлбөр баталгаажуулахад дараах шалгуурыг автоматаар шалгаж хангаж байгаа тохиолдолд хөтөлбөрийг баталгаажуулна. **Үүнд:**

- Тухайн сургалтын хөтөлбөрөөр сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа хүчинтэй байх
- Тусгай зөвшөөрөл дээрх мэргэжлийн чиглэлийн индекс, нэр, сургалтын хэлбэр, элсэгчдийн боловсролын түвшин, төгсөгчдөд олгох боловсролын зэрэг, агуулгын багтаамж, сургалтын хугацаа нь сургалтын хөтөлбөрийн харгалзах мэдээлэлтэй тохирч байх
- Сургалтын хөтөлбөрийн төлөв засварын горимд байх
- Хамгийн багадаа нэг төлөвлөгөө батлагдсан буюу идэвхтэй төлөвт байх
- Хөтөлбөрийн төлөвлөгөөний бүтцэд бүртгэсэн агуулга нь тусгай зөвшөөрөл дээрх агуулгын багтаамжаас их буюу тэнцүү байх
- Түвшин тогтоох дүрэм нь “Цуглуулсан багц цаг” сонгосон тохиолдолд сургалтын түвшин тодорхойлох дүрэмд заасан багц цагийн нийлбэр тусгай зөвшөөрлийн харгалзах агуулгын багтаамжаас их буюу тэнцүү байх.

Сургалтын хөтөлбөр баталгаажуулах үйлдлийг дараах дараалаар хийнэ. Үүнд:

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.
2. Сургалтын хөтөлбөрийн дэд хэсгээс **жагсаалт**ийг сонгоно.
3. Баталгаажуулах хөтөлбөрийн мөрний урд байрлах сум дээр дарж **засах** товчийг дарна.

4. Мэдээллийг шалгаад сургалтын хөтөлбөр нэмэх/засах цонхны баруун дээд хэсэгт байрлах **баталгаажуулах** товчийг дарна.
5. Баталгаажуулах шалгуур хангасан эсэхийг ДБУМС мэдэгдэнэ. Шалгуур хангасан бол сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө **идэвхтэй** төлөвт шилжинэ.

Сургалтын хөтөлбөр баталгаажуулах үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.




2. Сургалтын хөтөлбөрийн дэд хэсгээс **жагсаалт**ийг сонгоно.




3. Баталгаажуулах хөтөлбөрийн мөрний урд байрлах сум дээр дарж **засах** товчийг дарна.




4. Мэдээллийг шалгаад сургалтын хөтөлбөр нэмэх/засах цонхны баруун дээд хэсэгт байрлах **баталгаажуулах** товчийг дарна.




5. Баталгаажуулах шалгуур хангасан эсэхийг ДБУМС мэдэгдэнэ. Шалгуур хангасан бол хөтөлбөр, төлөвлөгөө идэвхтэй төлөвт шилжих ба шалгуур хангаагүй бол засварын горимтой хадгална.

---

## 6.4. Сургалтын хөтөлбөр устгах

**Хөтөлбөр устгах** үйлдэл нь системд нэвтэрсэн сургалтын байгууллагын хэрэглэгч өөрийн байгууллага дээрх үүссэн сургалтын хөтөлбөрийг устгах үйлдэл юм. Устгах үйлдэл хийхэд дараах шалгуур автоматаар шалгаж шалгуур хангаж байгаа тохиолдолд устгах үйлдлийг хийж хөтөлбөрийн жагсаалтаас хасна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн төлөв засварын горимд байх
- Сургалтын хөтөлбөрт суралцагч бүртгээгүй байх

Сургалтын хөтөлбөр устгах үйлдлийг дараах дарааллаар хийнэ. **Үүнд:**

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.
2. Сургалтын хөтөлбөр дэд хэсгээс **жагсаалт**ыг сонгоно.
3. Устгах хөтөлбөрийн мөрийн урд байрлах меню дээр дарж **устгах** сонголтыг сонгоно.
4. ДБУМС хөтөлбөр устгах боломжтой эсэх хариу мэдээлнэ. Дэд цонхны **устгах** товч дарна.

Сургалтын хөтөлбөр устгах үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.




2. Сургалтын хөтөлбөрийн дэд хэсгээс **жагсаалт**ийг сонгоно.




3. Засах сургалтын хөтөлбөрийн мөрийн урд байрлах меню дээр дарж **сургалтын хөтөлбөр устгах** сонголтыг сонгоно.



4. ДБУМС хөтөлбөр устгах боломжтой эсэх хариу мэдээлнэ. Дэд цонхны **устгах** товч дарна.



---

### 6.5. Сургалтын хөтөлбөр архивлах

ДБСБ нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө ашиглахаа болих үед **архивлах** үйлдэл хийнэ. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө архивлахын тулд тухайн хөтөлбөр, төлөвлөгөөнд бүртгэлтэй суралцагчдыг хөтөлбөр хооронд шилжүүлнэ. Архивласан төлөвтэй сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд суралцагч шинээр бүртгэх, шилжилт хөдөлгөөн хийх боломжгүй байна.

Сургалтын хөтөлбөр устгах үйлдлийг дараах дараалаар хийнэ. **Үүнд:**

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.
2. Сургалтын хөтөлбөр дэд хэсгээс **жагсаалт**ыг сонгоно.
3. Устгах хөтөлбөрийн мөрийн урд байрлах меню дээр дарж **архивлах** сонголтыг сонгоно.
4. ДБУМС хөтөлбөр архивлах боломжтой эсэх хариу мэдээлнэ. Дэд цонхны **хөтөлбөр архивлах** товч дарна.

Сургалтын хөтөлбөр архивлах үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.




2. Сургалтын хөтөлбөрийн дэд хэсгээс **жагсаалт**ийг сонгоно.




3. Засах сургалтын хөтөлбөрийн мөрийн урд байрлах меню дээр дарж **сургалтын хөтөлбөр архивлах** сонголтыг сонгоно.



4. ДБУМС хөтөлбөр архивлах боломжтой эсэх хариу мэдээлнэ. Дэд цонхны **хөтөлбөр архивлах** товч дарна.



---

## 6.6. Сургалтын төлөвлөгөө нэмэх

**Төлөвлөгөө нэмэх** үйлдэл нь системд нэвтэрсэн сургалтын байгууллагын хэрэглэгч өөрийн байгууллага дээрх үүссэн сургалтын хөтөлбөр дээр төлөвлөгөө нэмэх үйлдэл юм. Сургалтын хөтөлбөр нь дор хаяж нэг төлөвлөгөөтэй ба хэд хэдэн сургалтын төлөвлөгөөтэй байж болно.

Төлөвлөгөө нэмэх үйлдэл хийхээс өмнө **ДАРААХ НӨХЦӨЛ** биелсэн байх шаардлагатай. **Үүнд:**

- Хөтөлбөр бүртгэсэн байх
- Төлөв хүсэлт илгээгдсэн, архивлагдсан төлвөөс ялгаатай байх

Төлөвлөгөө нэмэх үйлдлийг дараах дараалаар хийнэ. **Үүнд:**

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.

2. Сургалтын хөтөлбөр дэд хэсгээс **жагсаалт**ыг сонгоно.
3. Засах сургалтын хөтөлбөрийн мөрийн урд байрлах меню дээр дарж **сургалтын хөтөлбөр засах** сонголтыг сонгоно.
4. Сургалтын хөтөлбөр засах цонхны **сургалтын төлөвлөгөө** хэсгийг сонгоно.
5. Сургалтын хөтөлбөр засах цонхны сургалтын төлөвлөгөө хэсгээс **Төлөвлөгөө нэмэх** товч дарна.
6. Төлөвлөгөө нэмэх дэд цонхны мэдээллийг оруулаад **нэмэх**

Төлөвлөгөө нэмэх үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Сургалтын хөтөлбөр** ерөнхий цэсийг сонгоно.




2. Сургалтын хөтөлбөр дэд хэсгээс **жагсаалт**ыг сонгоно.



3. Засах сургалтын хөтөлбөрийн мөрийн урд байрлах меню дээр дарж **сургалтын хөтөлбөр засах** сонголтыг сонгоно.




4. Сургалтын хөтөлбөр засах цонхны **сургалтын төлөвлөгөө** хэсгийг сонгоно.



5. Сургалтын хөтөлбөр засах цонхны сургалтын төлөвлөгөө хэсгээс **Төлөвлөгөө нэмэх** товч дарна.
6. Төлөвлөгөө нэмэх дэд цонхны мэдээллийг оруулаад **нэмэх**

